Уг нь хэвийн ажиллаж байсан боловч өнгөрсөн жилийн хурлыг СЗХорооноос хүчингүй гэж үзсэн учир ТУЗ ажиллах боломжгүй болсон. Зун болоод та нөхөд амраад эзгүй байсан тул дахин хурал зарлаж амжаагүй. 3500 м2-ын агуулахыг борлуулах гэж нилээд хичээж байгаа боловч аймаг орон нутагт худалдаад авчих бэлтэй хүн олдохгүй байна. УБ хотод Ремакс ҮХХөрөнгө зуучлалын газартай гэрээ хийгээд зар тавиулсан одоогоор сонирхох хүн гарахгүй л байна.

Өөр асуулт гараагүй тул асуултыг тасалж, хувьцаа эзэмшигчид үг хэлж, санал шүүмжлэл гаргав.

Д.Мөнх-Очир: Манай компани ХҮТөв, агуулах складаа бусдад түрээслэх ажлыг идэвхтэй явуулж ажиллавал нилээд орлого олох боломж байх шиг. Энэ түүхий эдийн ченжүүд гэр орнооroo түүхий эд авч хороолол заваруулж байгааг цэгцэлж нэг цэгт төвлөрүүлбэл хаа хаанаа хэрэгтэй л баймаар санагддаг юм. Эхлээд үнэ хөлсийг нь бага ч юмуу эсвэл 1-2 сардаа үнэгүй ч хамаагүй түрээслэж хүн татвал болохгүй юм болов уу гэж бодогдох юм.

Х.Нарантуяа: Хийж ирсэн худалдааны ажлаа орхиод ч яахав дээ. Өргөжүүлж л ажилламаар байна. Бусадтай өрсөлдөх арга ухаанаа сайжруулж бусдаас ялгагдах онцлогтойгоор үйл ажиллагаа явуулбал хүн татаж үйлчилгээний хүрээ нэмэгдэх байх. Тэр дэлгүүрээ доошлуулж худалдан авагчдад ойртуулах нь зөв байхаа.

Ц.Энхтуяа 3500 м2-ын агуулахаа урьдчилгаа аваад 1-2 жилийн дотор төлөхөөр найдвартай хүнд зээлээр худалдвал яасан юм Зарим хүний ярих нь үнэтэй хэлээд байна гэж сонсогдож байсан. Манай агуулах чинь чанар муутай баригдсан объект шүү дээ. Их засвартай гээд хүн авахгүй байгаа байх. Ашигтай ажиллах нь чухал байна.

Б.Ганбаяр: Урд агуулах, конторын цогцолборын агуулахын хэсгийг худалдаад өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж зээл авахаа болиод харин конторын хэсгийг нь засч зочид буудал болгоод жуулчны баазын өвөл хэрэглэдэггүй хөнжил гудас, цагаан хэрэглэлээ авчирч эргэлтэнд оруулж ашиглаж болно шүү дээ. Тэнд хүнсний мухлаг, гуанз ч ажиллуулж болно. Эхлээд аль нэг ҮХХөрөнгөө зарж эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх нь л зөв байх.

П.Аюусэд; 3500 м2-ын агуулах зарна гээд 2-3 жил боллоо. Уг нь юу ч хийж болох сав. Махны үйлдвэр байгуулахад ашиглаж болно гэж боддог. Тийм хүнд санал таьж үзээч. Бусад аймгууд махны үйлдвэртэй болоод л байна. Манай